



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА		Хуудасны дугаар
НЭГ.	УДИРТГАЛ	3-4
ХОЁР.	НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	
	2.1 Номын сангийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал	5-6
	2.2 Үндэсний номын сангийн зохион байгуулалт, чиг үүргийн хэрэгжилт	6-9
	2.3 Номын сангийн төрөл, үйлчилгээний хэрэгжилтийн талаар	9-13
	2.4 Уншигчийн эрх, үүргийг хангахтай холбоотой хуулийн хэрэгжилт	13-15
	2.5 Номын сангийн сан хөмрөг, санхүүжилт, дэмжлэгийн талаар	15-19
ГУРАВ.	ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	19-21

Хүснэгт, зургийн жагсаалт

- Хүснэгт 1. Үндэсний номын сангаас хэрэгжүүлсэн ажлын тоон мэдээлэл*
- Хүснэгт 2. Номын сангийн үйлчилгээний хэрэгжилтийн байдал*
- Хүснэгт 3. Номын сангийн заавал авах хувь*
- Хүснэгт 4. Үндэсний номын сангийн сүүлийн 5 жилийн нийт ном бүрдүүлэлт*
- Хүснэгт 5. Үндэсний номын сангийн санхүүжилтийн бүтэц*
- Хүснэгт 6. Үндэсний номын сангийн нийт санхүүжилт*
- Хүснэгт 7. Зардлуудын нийт зарлагад эзлэх хувь*
- Зураг 1. Нийтийн номын сангийн тоо*
- Зураг 2. Нийтийн номын сангийн суудлын тоо*
- Зураг 3. Номын сангийн тоо, байнгын уншигчид*
- Зураг 4. 2020 оны нийт зарлагад эзлэх хувь*

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтанд байна.”, 2 дахь хэсэгт “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.” гэж заасан.

Монгол Улсад 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд одоогийн Монгол Улсын Үндэсний номын сан байгуулагдсанаар орчин цагийн номын сангийн хөгжлийн эх үндэс тавигдаж, улсын хэмжээнд 1500 гаруй номын сан үйл ажиллагаагаа явуулж байна.

Ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш нийгэм, эдийн засаг, соёлын бүхий л салбарт ихээхэн өөрчлөлт, шинэчлэлт бий болж, шилжилтийн үеийн санхүүгийн бэрхшээлээс үүдэн номын сангийн салбарын хөгжил мэдэгдэхгүйц зогсонги байдалд орсон нь хот, хөдөөгийн номын сангуудын агуулгын болон үйлчилгээний, боловсон хүчний болон техник технологийн нэлээдгүй ялгаанаас харагдаж байна.

Улсын Их Хурлаас урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд ч номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлэх чиглэлээр томоохон зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

Зорилт 1.1.*Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулах:*

- ❖ 1.1.14. Дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, цахим хуудас бий болгоно.
- ❖ 1.1.16. Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулах цуврал бүтээлч үйл ажиллагааг улсын болон хувийн номын сангуудад түшиглэн зохион байгуулна.

Зорилт 1.2.*Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.*

- ❖ 1.2.4. Хүүхэд, залуучуудын театр, Хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхдийн хөгжлийн төвүүдийг дэмжиж, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Зорилт 1.4.*Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж,*

нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

- ❖ 1.4.8. Дэлхийн номын сангууд болон угсаатны зүйн музей, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хүмүүст хадгалагдаж байгаа бичгийн дурсгал, түүхэн сурвалж бичгийн өвийг бүртгэж мэдээллийн сан бүрдүүлж, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулна.

Зорилт 9.1. *Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.*

- ❖ 9.1.4. Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна.

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ирүүлсэн саналаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу "...хууль тогтоомжийн зорилтыг хангаж байгаа түвшинг тодорхойлох, хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох" чиглэлээр хяналт шинжилгээ хийнэ гэж заасан байх тул Улсын Их Хурлын Тамгын газраас Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу хяналт шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг тодорхойлох, уг хуулийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь хяналт шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийн явцыг тодорхойлохдоо тохирох хэмжүүрийг сонгон, холбогдох мэдээллийг Соёлын яамны Соёл, гэгээрлийн газраас ирүүлсэн албан эх сурвалж болон Үндэсний номын сангийн номын санч нараас авсан албан бус эх сурвалж, холбогдох судалгаа, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэсэн болно.

Гэвч хуулийн хэрэгжилтийн явц байдлыг тодорхойлох үүднээс холбогдох төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, цахим орчинд буй мэдээлэл нь хангалттай бус байсан.

Зорилго

Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал болон уг хууль нь анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч чадаж байгаа эсэхийг судалж, цаашид хуулийн хэрэгжилтийг тогтвортой болгоход хувь нэмэр оруулах явдал юм.

Зорилтууд

- Номын сангийн тухай хуулийн зорилгыг тодорхойлж, хэрэгжилтийг тодорхойлох тохирох хэмжүүрийг сонгох, мэдээллийг нэгтгэн цуглуулж, дүн шинжилгээ хийх;
- Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайланг БСШУСБХ-нд хүргүүлэх зэрэг болно.

ХОЁР. НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

2.1 Номын сангийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал:

Монгол Улсын хэмжээнд одоогоор 365 нийтийн номын сан ойролцоогоор 10.6 мянган суудал бүхий уншлагын танхимаар жилд 277.1 мянган байнгын уншигчид номын сангийн үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн их, дээд сургуулийн 101, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн 54, ерөнхий боловсролын сургуулийн 844, албан байгууллагын дэргэд 120, эрдэм шинжилгээний 44 номын сан байна¹.

Нийтийн номын сан
365



Номын сангийн
сан хөмрөг
6.2 сая

10.6 мянган
суудал бүхий
уншлагын
танхим



277.1 мянган
байнгын
уншигч

Эдгээр номын сан нь харьяаллын хувьд олон салбарт хамаардаг бөгөөд соёлын болон санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна. Харьяалал, салбар дундын зохицуулалтаас хамааран номын сангийн санхүүжилт, сан хөмрөгийн бүртгэл, тооцоо, уншигчид үйлчлэх орчин нөхцөл, номын хадгалалтын орчин зэрэг асуудал нь жигд бус шийдвэрлэгддэг байна.

Тухайлбал, Ерөнхий боловсролын сургуулийн болон их, дээд сургуулийн номын сан нь нийтийн номын сангуудаас онцлог ялгаатай байдаг ч эрх зүйн зохицуулалтын хувьд ялгаатай байдлыг нарийвчлан тусгаагүй байна.

Номын сангийн үндсэн зарчмын нэг бол түүний үйлчилгээ нь бүх иргэдэд хүртээмжтэй, ямарваа нэг хэсэг бүлэг иргэдээр хязгаарлагдахгүй байх ёстой бөгөөд номын санд ирж чадахгүй байгаа цөөнхийн бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, алс хол амьдардаг, номын сангийн үндсэн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа иргэдэд хүргэх тал дээр арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байдаг.

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт ч дээрх зарчимд үндэслэх бөгөөд хэрэглэгчдийн онцгой бүлэгт тохирсон хэлбэртэй тухайлбал, брайлын ном, хараагүй хүмүүст зориулсан “ярьдаг ном” гэх мэт байх ёстой юм.

Иргэдэд ном, хэвлэл мэдээллээр үйлчлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд туслах, мэдээллийг хүн бүрт эрх тэгш хүргэх зарчмыг хэрэгжүүлэн мэдээллийг

¹https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2002_001V1&13999001_select_all=1&13999001SingleSelect=&SOU M_select_all=1&SOUMSingleSelect=&YearY_select_all=1&YearYSingleSelect=&viewtype=

технологийн дэвшлийг ашиглан цахим болон хэвлэмэл хэлбэрээр үйлчлэх, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах үүднээс Улсын Их Хурлаас 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Номын сангийн тухай хуулийг баталсан бөгөөд батлагдсанаас хойших цаг үеийн нөхцөл байдал болон бусад хууль тогтоомжтой уялдуулан нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Номын сангийн хуулийн зорилт нь номын сангийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, номын сангийн төрөл, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, уншигчийн эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд нийт 7 бүлэг, 26 зүйлтэйгээр батлагдсан.

Үндэсний номын сан нь өнгөрсөн хугацаанд номын сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх 20 гаруй дүрэм, журам, стандартыг боловсруулан баталж, номын сангийн үйл ажиллагаа, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас батлагдаж буй урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ч номын сангийн үйл ажиллагааг хөгжүүлэн төрөлжүүлэх, уншлага дэмжих, соёл олон нийтийн ажлыг өргөжүүлэх, үндэсний хэл, соёлын онцлогийг илэрхийлсэн агуулгаар баяжуулах зэрэг томоохон зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Үндэсний номын сан өөрийн сан хөмрөг дэх ном, хэвлэлийн мэдээг уламжлалт каталогаос е-каталогт “Lib-4U”, “КОХА” зэрэг программд хөрвүүлэн, онлайнгаар нийтэд сурталчлан мэдээлэх болсноос гадна номын санг автоматжуулах, электрон эрэл хайлтад зориулсан дээрх программын үндсэн дээр үйл ажиллагаагаа автоматжуулсаар ирсэн байна.

2000 оноос L-Soft системийг нэвтрүүлж, Олон улсын программ хангамжуудыг судалсны үндсэн дээр 2015 оноос Шинэ Зеландын “КОХА” программыг өөрийн номын санд нутагшуулан сан хөмрөгөөс үе шаттай цахим каталогт шилжүүлэх ажлыг хийсээр иржээ.

Түүнчлэн сүүлийн 5 жилд Монгол номын сан хөмрөгийн 200 мянга гаруй, 12 мянга гаруй диссертац, дорно дахины сан хөмрөгийн 30 мянга орчим хятад ном, архивын сан хөмрөгт хадгалагдаж буй 30 мянга орчим, төвөд номын сан хөмрөгийн 22 мянга гаруй ном судар, ЮНЕСКО-гийн сан хөмрөгийн 9 мянга орчим, өрнө дахины сан хөмрөгийн 166 мянган ном зэрэг нийт 469 мянга орчим ном, судар буюу нийт сан хөмрөгийн 60.0 хувийг электрон каталогт оруулсан байна.

Техник технологийн хөгжил, дэвшлийг даган номын сангууд өөрт цөөн хувьтай байгаа болон зохиогчийн эрх хөндөхөөргүй ном, хэвлэлийг тоон хэлбэрт оруулж, цахимаар /уншлагын танхимд/ уншуулах болсон байна.

Номын сангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах болон ганц хувь бүтээл, гар бичмэлийг цахим болон хуулбар хэлбэрээр уншуулна” гэж заасны дагуу Үндэсний номын санд хадгалагдаж буй ганц хувь, гар бичмэл, барын ном судрыг тоон хэлбэрт шилжүүлж, эхийг тусад нь хадгалж, нийтийн хүртээл болгоход эртнээс анхаарч үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж ирсний дүнд одоогийн байдлаар 8 мянга гаруй ном судрыг тоон хэлбэрт шилжүүлж, Эрдэм шинжилгээний уншлагын танхимаар үйлчилж байна.

2.2. Үндэсний номын сангийн зохион байгуулалт, чиг үүргийн хэрэгжилт:

Үндэсний номын сан нь монголын ард түмний бичиг үсгийн дурсгалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлыг зохион байгуулах, бусад номын санг эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах чиг үүрэгтэйгээр 5 хэлтэс, үндсэн 112 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндэсний номын сангийн барилга 1951 онд ашиглалтанд орсноос хойш 63 жил өнгөрч, тухайн үед 500 мянган номтой байсан тус номын сан эдүгээ 3 сая гаруй номтой, 9 фонд, 5 уншлагын танхимаар уншигч, хэрэглэгчид, эрдэмтэн судлаачдад үйлчилж байна.

Тус номын сангийн номын тоо, үйлчлэх хүрээ нь жил бүр өсөн нэмэгдэж байгаагаас уншлагын танхим, фондын даац, орчин нөхцөл нь өнөөгийн стандарт шаардлагад нийцэхгүй, номын сангийн аюулгүй ажиллагааг хангах асуудал ч тулгамдсан хэвээр байсан юм.

Хуулийн Гуравдугаар бүлэгт Үндэсний номын сангийн үйл ажиллагаа, эрх зүйн байдал, чиг үүргийг талаар зохицуулсан бөгөөд хэрэгжилтийн байдлыг дараах байдлаар гаргалаа.

Үндэсний номын сангийн зорилго нь гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, Монгол Улсад хэвлэгдсэн ном, сонин, сэтгүүл болон хэвлэлийн бусад бүтээгдэхүүн, чухал хэрэгцээтэй гадаад ном зохиол, тогтмол хэвлэлийг бүрдүүлэн хадгалах, бүртгэл мэдээллийн сан бий болгох, уншигчид шуурхай үйлчлэх, бусад номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангана гэж тодорхойлсон байна.

Номын сангийн үйл ажиллагааг номын сангийн орчны стандартыг хангасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэн эрхэлж болохыг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан байдаг.

Номын сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд Үндэсний номын сангийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж, Үндэсний номын сангийн дэргэд орон тооны бус **Эрдмийн зөвлөл** болон **Мэргэжлийн зөвлөл** ажиллах бөгөөд эдгээр зөвлөлүүдийн ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 570 дугаар тушаалаар Төв, орон нутгийн нийтийн номын сан, бүх шатны сургуулийн дэргэд орон тооны бус "Номын сангийн зөвлөл"-ийн ажиллах нийтлэг журмыг баталсан.

Эрдмийн зөвлөл нь салбарын эрдэм шинжилгээ-судалгааны ажлын чиглэлийг тогтоох, эртний ном судар, гар бичмэлийг судалгааны эргэлтэд оруулах, номын сан-ном зүйн судлал, арга зүйн чиглэлээр зөвлөгөө өгч ажиллана.

Харин мэргэжлийн зөвлөл нь мэргэжлийн гарын авлага, ном, сурах бичигт дүгнэлт өгөх, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, номын сангийн ном бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх, уншигчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн баяжилт хийх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний номын сангийн удирдлагад санал оруулахаар заасан байна.

Номын сангийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгууллагын ерөнхий менежер томилох бөгөөд төвийн болон орон нутгийн захиргаа, боловсрол, соёл, олон нийтийн байгууллага, уншигчдын төлөөлөл бүхий 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр жилд хоёроос доошгүй удаа хуралдахаар журамд тусгасан.

Үндэсний номын сангийн зөвлөл нь Номын санг шинэчлэх хэтийн болон жилийн төлөвлөгөөнд санал оруулах, номын баяжилт, ном бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, уншлага үйлчилгээний ажлын чанарыг сайжруулах, уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ном хэвлэлээр баяжилт хийх, мэдээллийн хангамжийн хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэн ажилладаг байна.

Гэвч Номын сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, хуралдаан, зөвлөлөөс гаргасан шийдвэр зэргийн талаарх мэдээлэл хангалтгүй байсан төдийгүй хяналт шинжилгээ хийх явцад олдоогүй болно.

Номын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Үндэсний номын сан энэ хуулийн 7.1-д зааснаас гадна үндэсний ном зүйн нэгдсэн мэдээллийн санг байгуулах ажлыг зохион байгуулах, бусад номын санг эрдэм шинжилгээ-судалгаа, мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэвлэлийн бүтээгдэхүүнийг сэргээн засварлах ажлыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.” гэж заасан байдаг.

Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 8 дүрэм, журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаас одоогийн байдлаар нийт 5 журам нь батлагдаж, 3 журмыг нь батлаагүй байна. Тухайлбал, Цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх журам, Нөхөн бүрдүүлэх журам, Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх журмууд батлагдаагүй байна.

Номын сангийн орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 5742:2007, Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага MNS ISO 11799: 2007 зэрэг Үндэсний болон олон улсын стандартуудыг бүх төрлийн номын сангууд үндсэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд 2019 онд эдгээр стандартуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан байна.

Үндэсний номын сан нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх төрлийн номын санг мэргэжил-арга зүйн удирдлага, номзүйн мэдээллээр хангах үндсэн үүргийг гүйцэтгэж, номын сангийн үйл ажиллагааг зохицуулах аргачлал, зөвлөмж, дүрэм, журам, стандартыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг хийж байна.

Өөрөөр хэлбэл, Үндэсний номын сан нь өнгөрсөн таван жилийн хугацаанд номын сангийн салбарт мөрдөгдөх 20 гаруй дүрэм, журам, стандартыг боловсруулж гаргасан нь номын санд хүчин төгөлдөр үйлчилж, номын сангийн үйл ажиллагааг

боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: “MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” Үндэсний стандарт, “MNS ISO11799:2019 Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага” стандарт Үндэсний стандарт, “Уншлагыг дэмжих журам” /2018 он/, “Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам” /2019 он/, “Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл хадгалж байгаа хувийн номын санд дэмжлэг үзүүлэх журам” /2020 он/, “Түүх болон судалгаа шинжилгээний ач холбогдол бүхий ном судрыг нөхөн бүрдүүлэх журам”, “Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах зөвлөмж”, “Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийн байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”, “Монгол Улсын Үндэсний номын сангийн дүрэм, бүтэц”, “Монгол Улсын Үндэсний номын сангийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”, Монгол Улсын Үндэсний номын сангийн нэрэмжит шагнал "Ном цом" олгох журам зэргийг дурдаж болох юм.

“ЮНЕСКО-ийн уншлагын танхимын ном хэвлэлийг номын сангийн стандартын дагуу зохион байгуулах аргачлал-2017”, “ЮНЕСКО-гийн фондын номыг тоолох аргачлал-2017”, “Ойрын номын фондыг тоолох аргачлал-2017”, “Цахим төлбөрт үйлчилгээний танхимын журам-2017”, “Ерөнхийлөгчийн нэрэмжит эрдэм шинжилгээний уншлагын танхимын журам-2017”, “Өрнө дахины сан хөмрөгийн номыг тоолох аргачлал-2017” зэрэг шаардлагатай аргачлал, зөвлөмжийг тухай бүр Үндэсний номын сангийн Мэргэжлийн зөвлөл боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Мэргэжлийн онол, арга зүйн материалаар хангадаг "Номын санч" сэтгүүлийг 1975 оноос эдүгээ 45 дахь жилдээ тасралтгүй бэлтгэн жилд хоёр дугаар хэвлүүлэн номын сангуудад үнэ төлбөргүй тарааж байгаа нь номын санчид, багш, оюутан, мэргэжилтний өдөр тутмын гарын авлага болж байна. Мөн "Нийтийн номын сангуудын тайлан эмхэтгэл"-ийг эмхэтгэн цахим хэлбэрээр веб сайтад байршуулж, нийтийн номын сангуудын тайланд дүн шинжилгээ хийж 2018 оноос эхлэн жил бүр шалгаруулж Үндэсний номын сангийн нэрэмжит “Ном цом” шагналыг олгож байна.

Хүснэгт 1. Үндэсний номын сангаас хэрэгжүүлсэн ажлын тоон мэдээлэл

Он	Сургалтын тоо	Мэргэжлийн зөвлөгөө	Томилолт
2015	6	100	6
2016	10	145	16
2017	8	120	8
2018	7	98	11
2019	7	95	7
2020	6	109	2
Нийт	44	667	50

Үндэсний номын сан 6-7 аймагт томилолтоор очиж ажиллахаас гадна номын санчдын мэргэжил дээшлүүлэх сургалт семинарыг жилд дунджаар 4-6 удаа, эрдэм шинжилгээ, онол-практикийн бага хурлыг тогтмол зохион явуулж, хот, хөдөө орон нутгийн болон их, дээд сургуулийн номын санчдад жилдээ 90-120 удаа арга зүйн зөвлөлгөө өгч ажилласан байна.

Номын санчдын ажлыг хөнгөвчлөх, лавлагаа мэдээллийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн сангаа хамтран ашиглах зорилгоор хийсэн ажлын нэг нь 2018 оноос 47 номын сантай гэрээ байгуулан ажиллаж, “Zotero” программаар “Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”-г бий болгох суурийг тавьж, одоогийн байдлаар 85 мянга гаруй өгүүллийн мэдээллийн сантай болсон байна.

2.3.Номын сангийн төрөл, үйлчилгээний хэрэгжилтийн талаар:

Номын сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу номын сан нь нийтийн, сургалтын, эрдэм шинжилгээний болон бусад төрөлтэй байх бөгөөд номын сангийн үйлчилгээ нь үндсэн ба нэмэлт үйлчилгээ байхаар заажээ.

Сургалтын номын сан нь бүх шатны боловсролын байгууллагад байх бөгөөд багш, суралцагчийн сурч, хөгжих үйл явцыг дэмжихэд чиглэгдсэн үйлчилгээ үзүүлдэг байна. Манай улсын хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулийн 844 номын сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр номын санд 705 номын санч ажиллаж, 680.8 мянган сурагч, 54.5 мянган багш, ажилчдад үйлчилдэг байна.

Нийслэл, аймаг, сумдын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд номын сан хариуцсан мэргэжилтэн хангалтгүй байгаа бөгөөд номын санчийн мэргэжилтэй номын санч 288 буюу 40.8 хувь, номын санчийн мэргэжилгүй (багш болон бусад мэргэжилтэй) номын санч 417 буюу 59.2 хувь нь байна. Өөрөөр хэлбэл, сургалтын номын сангийн хувьд мэргэжлийн номын санчдыг ажиллуулах, мэргэшүүлэх, давтан сургах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Сургалтын номын сангийн хувьд Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах MNS 5742:2019 стандартыг үйл ажиллагаанд мөрдөх боловч номын сангийн орон зай, багтаамж хүрэлцээ бага, ажлын болон уншлагын танхим орчин нөхцөл хангалтгүй зэрэг нь дийлэнх номын сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Мөн номын тавиур, уншлагын танхимын ширээ, сандал хүүхдийн эрүүл ахуй, аюулгүй байдал, нас, бие бялдрын онцлогт нийцэхгүй байх, номын сангийн программ хангамжийн хэрэглээ бага, техник хэрэгслийн хангамж хүрэлцээ хангалтгүй, хоцрогдсон зэрэг тулгамдаж буй асуудлууд байна.

Эрдэм шинжилгээний номын сан нь судалгаа, шинжилгээ, мэдээллийн түшиц газар байж, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий үйлчилгээг үзүүлнэ.

Манай улсад одоогоор 88 их, дээд сургуульд 148 мянган суралцагч, 12 мянган ажилтан, шинжлэх ухааны салбарын 62 байгууллагад 4254 ажилтан байна². Гэвч томоохон их сургуулиуд болох МУИС, ШУТИС, АШУҮИС, МУБИС, ХААИС, ҮБХИС, ИЗОУИС зэрэг нийт их, дээд сургуулийн 44 хувь нь номын сангийн тусдаа бие даасан байртай төдийгүй эдгээр номын сангууд нь дор бүрнээ цахим сан хөмрөгтэй болох ажлыг эхлүүлж, дотооддоо үүсгэсэн цахим санг зөвхөн өөрийн бүртгэлтэй уншигчиддаа ашиглуулдаг байна.

Дээрх нийт номын сангийн ажилтнуудын 80.0 хувийг мэргэжлийн номын санчид эзэлж байгаа бөгөөд дунджаар тогтмол 5 мянга орчим байнгын уншигчид үйлчилдэг ч хяналт шинжилгээний судалгааны явцад дараах тулгамдаж буй асуудлуудыг тодорхойллоо.

- Их, дээд сургуулиуд цахим мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, хамтарч ашиглах, оюуны бүтээл хуулбарлалт шалгах программ хангамжийг нэгдсэн байдлаар ашиглах мэдээллийн бааз бүрдүүлэх шаардлага бий болсон.
- Номын санчид 4 жилээр бакалаврын зэрэгтэй номын сан мэдээллийн ажилтнаар төгсдөг ч номын санд хэрэгтэй шаардлага хангасан мэргэжлтэн

² https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_1


хангалтгүй байна. Ном зүйч, каталогич, лавлагаа мэдээллийн ажилтан, хэрэглэгчидтэй харилцах ажилтан, мэдээллийн технологийн инженер, веб хөгжүүлэгч, техник тоног төхөөрөмжийн инженер гэх мэт нарийн мэргэжлийн орон тоотой болгох ажлыг бодлогоор зохицуулах хэрэгтэй болсон.

- Их, дээд сургуулийн номын сан нь нийтийн номын сангуудаас онцлог ялгаатай, эрдэм шинжилгээний номын сантай илүү ижил төстэй үйлчилгээтэй байдаг тул их, дээд сургуулийн номын сангийн статусыг тодорхой болгох зэрэг болно.

Нийтийн номын сан нь арьс өнгө, үндэстэн ястан, шашин, шүтлэг, хэл, хөдөлмөрийн чадвар, эдийн засгийн байдал, ажил, боловсролын түвшин харгалзахгүйгээр уншигчид тодорхой хугацаанд ашиглуулах зориулалттай сан хөмрөг бүхий мэдээлэл, соёл, боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, нэгжийг хэлдэг бөгөөд "Номын сангийн тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Нийтийн номын сан нийгмийн бүх гишүүнд үйлчилгээ үзүүлнэ." гэж баталгаажуулж өгсөн.


Номын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Номын сангийн үндсэн үйлчилгээ нь уншлагын танхимын үйлчилгээ байна." гэж заасан байдаг. Номын сан нь уншигчид гэрээр ном олгох үйлчилгээ, зөөврийн номын сангийн үйлчилгээ, цахим уншлагын үйлчилгээ, ном зүйн үйлчилгээ, тусгай бүлгийн уншигчийн хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ болон бусад хэлбэрээр үйлчилгээ үзүүлнэ.

Зураг 1. Нийтийн номын сангийн тоо³



Одоогийн байдлаар нийтийн 365 номын сан үйл ажиллагаагаа явуулж, нийт сан хөмрөгийн тоо 6.2 сая, байнгын уншигч 277.1 мянга, уншлагын танхимын суудлын тоо 10.6 мянга байна.

Зураг 2. Нийтийн номын сангийн суудлын тоо⁴



Номын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд номын сангийн үйлчилгээний төрөл, хэлбэрийн талаар зохицуулсан бөгөөд номын сангийн үйлчилгээ нь үндсэн ба

³ https://1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_2&year=2019

⁴ https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Yearbook2020.all_link..pdf&ln=Mn

нэмэлт үйлчилгээнээс бүрддэг. Мөн номын сангийн үйлчилгээний хэлбэрийг тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т дараах байдлаар хуульчлан зохицуулсан байна.

- Уншлагын танхимын үйлчилгээ;
- Гэрээр ном олгох үйлчилгээ;
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ;
- Цахим уншлагын үйлчилгээ;
- Ном зүйн үйлчилгээ;
- Тусгай бүлгийн уншигчийн хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээ;
- Бусад гэсэн хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх бөгөөд хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний явцад гэрээр ном олгох үйлчилгээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл олоогүй болно.

Харин бусад үйлчилгээний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар үйлчилгээ тус бүрээр дараах байдлаар авч үзлээ.

Хүснэгт 2.Номын сангийн үйлчилгээний хэрэгжилтийн байдал

Үйлчилгээний төрөл	Хэрэгжилтийн байдал
Уншлагын танхимын үйлчилгээ:	2020 оны байдлаар Нийтийн номын сангаар үйлчлүүлэх үнэмлэхийг их уншлагын танхимд 2792 уншигчид, эрдэм шинжилгээний уншлагын танхимд 541 уншигчид олгож нийт 3333 уншигчдыг шинээр бүртгэж, үнэмлэх сунгалт 753 уншигчид олгосон байна. Мөн хувилах үйлчилгээний карт цэнэглэлтээр 22.2 сая төгрөгийн орлого оруулсан байна. Уншигчийн үнэмлэхийн хэвлэлтийг сайжруулан, дугаарыг товгор хэвлэлийн аргаар хийлгэж, шинэчлэн "Ном хур" хэвлэлийн газартай гэрээ байгуулжээ.
Зөөврийн номын сангийн үйлчилгээ:	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Номын сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах бүх нийтийн соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор алслагдсан нутаг дэвсгэрийн иргэд /тусгай байгууламжид буй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс/-т төлөвлөгөөний дагуу зөөврийн номын сангийг үйлчилгээг үзүүлэх зорилгоор БСШУС-ын сайдын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/821 дүгээр тушаалаар “Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Үндэсний номын сан улсын хэмжээний нийтийн номын сангуудын зөөврийн номын сангийн үйлчилгээний тайлан мэдээг улирал бүр авч, нэгтгэдэг байна. 2015-2017 онд Зөөврийн номын сангийн хүрээнд олон төрлийн "Номын хандив" аян өрнүүлж, Сэлэнгэ аймгийн төвд байрлах хилийн 0243, 0101 дүгээр анги болон 0243 дугаар ангийн Номтын застав, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн албан бус боловсролын "Гэгээрэл" төв, Багануур дүүргийн хорих 427 дугаар анги, Эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги, хаалттай хорих 429 дүгээр анги зэрэгт тус тус хүрч үйлчилжээ. 2018 онд зөөврийн номын сангийн үйлчилгээг 10 удаа 325 номоор үйлчилсэн ба 140 номыг хандиваар өгсөн. Үйлчилгээний хүрээг өргөжүүлэх үүднээс Авто тээврийн газартай хамтран хот хоорондын тээврийн автобусанд “Номтой автобус” төслийг 2018 онд эхлүүлэн зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн.

2019 онд аймаг, нийслэлийн төв номын сангууд болох 24 номын сан 718 байгууллагатай гэрээ байгуулж, 67685 иргэнд зөөврийн 67737 ширхэг номоор үйлчилж, алслагдсан дүүрэг, сум, баг, тусгай байгууламж хорих анги, цэцэрлэг, сургууль, төрийн бус байгууллагуудтай хамтран номын сангийн Соёл олон нийтийн ажлыг 1315 удаа зохион байгуулж, 70918 хүнийг хамруулсан байна.

2020-2021 онд дэлхий нийтийг хамарсан /КОВИД-19/-ын цар тахлын хөл хорио тогтоосон хугацаанд соёл, урлагийн үйлчилгээ тэр дундаа зөөврийн номын сангийн үйлчилгээ хязгаарлагдаж, 2019 онтой харьцуулахад 50-60 хувьтай байна. 2020 онд аймаг, нийслэлийн төв номын сангууд болох 24 номын сан 450 байгууллагатай гэрээ байгуулж, 37591 иргэнд 39088 ширхэг номоор зөөврийн номын сангийн үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн алслагдсан дүүрэг, сум, баг, тусгай байгууламж хорих анги, цэцэрлэг, сургууль, төрийн бус байгууллагуудтай хамтран номын сангийн Соёл олон нийтийн ажлыг 587 удаа зохион байгуулж, 446120 иргэнийг хамруулжээ.

Цахим
уншлагын
үйлчилгээ:

Техник технологийн хөгжил, дэвшлийг даган номын сангууд өөрт цөөн хувьтай байгаа болон зохиогчийн эрх хөндөхөөргүй ном, хэвлэлийг тоон хэлбэрт оруулж, цахимаар /уншлагын танхимд/ уншуулах болсон.

/КОВИД-19/-ын цар тахлын нөхцөлд цахимаар ном захиалан унших, шинэ номын танилцуулга, цахим худалдаа, үзэсгэлэн зохион байгуулжээ. Тухайлбал, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан дэлхийн шилдэг 10 номыг цахимаар танилцуулсан байна.

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан “DAISY” стандартад нийцүүлэн E-PUB 90 ширхэг цахим ном бүтээсэн байна. Харааны бэрхшээлтэй иргэдийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээний албан ёсны цахим хуудсанд 50 удаагийн мэдээ мэдээлэл оруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн “youtube” сувагт 50 удаагийн дүрстэй мэдээлэл оруулсан байна.

Монгол хэлний ярьдаг программ суулгах, тохируулах 26 удаагийн заавар зөвлөлгөө, NVDA дэлгэц уншигч компьютерийн программ ашиглах зааврын талаар 19 удаагийн 19 зөвлөмж, цахим брайль төхөөрөмж ашиглах 20 удаагийн зөвлөмж, цахим ном тоглуулагчийг ашиглах 15 удаагийн зөвлөмж буюу 2020 онд нийт 80 мэдээлэл харилцааны технологийн зөвлөмжийг шууд болон цахим хэлбэрээр үйлчилсэн байна.

Интернэт сүлжээ, утасгүй интернэт ашиглах, цахим ном хэвлэл, сургалтын материал ашиглах тахим байгуулах, техник хэрэгслээр хангах ажил дутмаг, уншигчдын нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн, ганцаарчилсан, бүлгийн, чөлөөт уншлагын танхим байгуулах ажлыг зохион байгуулах шаардлага бий болсон байна.

Хүртээмжтэй
ном хэвлэл
бүтээх үйл
ажиллагаа:

Хүртээмжтэй форматын ном гэдэг нь хэвлэмэл номыг компьютерийн файл болгож хүртээмжтэй байдлаар боловсруулж хуудас, бүлэг хэсэг, гарчиг бүрээр унших, тэмдэглэл хийх, бичвэр хайлт хийх, зогссон хэсгээс үргэлжлэн унших зэрэг боломжуудыг бүрдүүлсэн байдаг.

2.4. Уншигчийн эрх, үүргийг хангахтай холбоотой хуулийн хэрэгжилт:

Номын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд Номын сангийн уншигчийн эрх,

үүргийн эрх зүйн харилцааг зохицуулсан бөгөөд уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “уншигч” гэж номын сангийн үйлчилгээг хүртэгч, иргэн, хуулийн этгээдийг, мөн зүйлийн 3.1.7-д “тусгай бүлгийн уншигч” гэж “хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон номын санд биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэнийг хэлнэ.” гэж тодорхойлжээ.

Харааны бэрхшээлтэй иргэдийн номын сангийн үйлчилгээний хувьд улсын хэмжээнд 11.8 мянга гаруй харааны бэрхшээлтэй иргэд байгаагаас Улаанбаатар хотод 3000 гаруй иргэд бусад нь орон нутагт оршин суудаг тоо баримт байна.

Харааны бэрхшээлтэй иргэдэд одоогоор 5 номын сангийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд сард 150-300 иргэн нь идэвхтэй уншигч байна. Өөрөөр хэлбэл, жилд 3000-3600 харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг бөгөөд нийт 11.8 мянга гаруй харааны бэрхшээлтэй иргэдийн 50.0 хувиас илүү нь номын санд очих боломжгүй байдалд байна.

2003 онд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэд ярьдаг номын студи байгуулагдаж харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан аудио форматаар CD, кассетанд бичигдсэн номыг Улаанбаатар хотын төв номын сангаар харааны бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд 2004 онд ээлтэй иргэдийн уншлагын танхим нээгдэж 2010 он хүртэл 200 гаруй ярьдаг ном, 150 гаруй брайль ном хэвлэлээр үйлчилгээ үзүүлсэн байна.

2021 оны байдлаар харааны бэрхшээлтэй иргэдэд зориулагдан бүтээгдсэн нийт ном хэвлэлийн тоо 1500 гаруй байгаа гэсэн тоо баримт бий бол үүнээс 1000 гаруй цахим хүртээмжтэй хэлбэрээр ном, брайль хэвлэлийн 500 гаруй нэрийн ном тус тус эзэлж фонд бүрдүүлсэн байна. Үүнийг нийтийн номын сангийн сан хөмрөгийн тоотой харьцуулан үзвэл улсын хэмжээнд ойролцоогоор 0.24 буюу маш бага хувийг эзэлж байна.

2010 онд тус уншлагын танхим нь шинээр зохион байгуулагдаж “Харааны бэрхшээлтэй иргэдийн номын сангийн брайль болон цахим номын сангийн үйлчилгээ” бий болсон. Энэ хүрээнд “DAISY” олон улсын хүртээмжтэй ном хэвлэлийн стандартыг нэвтрүүлж, “DAISY” номын студи байгуулагдаж хүртээмжтэй форматын ном бүтээж эхэлсэн.

2016 онд Улаанбаатар хотын номын санд хүртээмжтэй технологийн төв байгуулагдан дэвшилтэд технологудыг номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлж, “Assistive technology” буюу туслагч технологийн судалгаа хөгжүүлэлт явуулж эхэлсэн байна. Үүнд:


- “E-braille technology” буюу цахим брайлиар уншиж бичдэг “Orbit reader” анхны монгол брайль дэмждэг төхөөрөмжийг хэрэглээнд оруулсан.
- Олон улсад хамгийн өргөн хэрэглэгддэг “NVDA” дэлгэц уншигч компьютерийн программыг монгол хэлээр орчуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Бичвэрийг яриа болгодог монгол хэлний ярьдаг программыг хөгжүүлж хэрэглээнд оруулсан байна.

Эдгээр шийдлүүдийн тусламжтайгаар харааны бэрхшээлтэй иргэд компьютерийн хэрэглээний программууд, интернэт орчинд ажиллах, хүмүүстэй харилцах сошиал медиа ашиглах, түүнчлэн хамгийн сүүлийн үеийн “DAISY-E-PUB”

форматын ном, бусад олон төрлийн цахим контентуудыг хүлээн авах технологийн нөхцөлөөр бүрэн хангагджээ.

Олон улсын хэмжээнд цахим брайль төхөөрөмж, “DAISY” ном тоглуулагч гэх мэт төхөөрөмж, гар утасны апп зэрэгт уншигдах үндсэн 4 төрлийн хүртээмжтэй форматыг хөгжүүлж, контентуудыг бүтээсэн байна.

Зураг 3. Нийтийн номын сангийн тоо, байнгын уншигчид /мян.хүн/



Уншигчийн эрхийг номын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт “стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг авах”-ыг хэрэгжилт хангалтгүй гэж үзэхээр байна. Тухайлбал, 2021 оны III улирлын байдлаар Үндэсний номын сангийн өргөтгөлийн барилгын ажлын үйл явц 87 хувьтай явагдаж байна.

Үндэсний номын сангийн шинэ барилгын зураг төслөөр уг барилга нь нийт 11 давхар бөгөөд барилгын 1-3 давхарт чөлөөт сонголт бүхий төрөлжсөн уншлагын танхимууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон гэр бүлийн уншлагын танхим, интернет танхимууд байрлах ба 5-аас дээш давхарт үндсэн фондууд байрлахаар төлөвлөгджээ.

Мөн уг шинэ номын сан 450 хүний суудалтай, олон улсын стандарт, жишигт нийцсэн техник технологийн шийдэлтэй байх юм. Чөлөөт сонголттой, төрөлжсөн, цахим уншлагын танхимаар үйлчилгээ үзүүлж, ном хэвлэлийг сканердан тоон хэлбэрт шилжүүлэх, аудио, видео, брайль ном боловсруулах тусгай өрөө, мини театр, хурлын танхимтай байхаар төлөвлөн ажиллаж байна.

2.5. Номын сангийн сан хөмрөг, санхүүжилт, дэмжлэгийн талаар:

Номын сангийн сан хөмрөг, бүрдүүлэлт: Номын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Номын сангийн сан хөмрөгийг заавал худалдан авах хувь, худалдан авах, нөхөн бүрдүүлэх, ном солилцоо, хандив тусламж, өв залгамжлал, бусад гэсэн хэлбэрээр бүрдүүлдэг байна.

Оюуны бүтээлийн архив, үндэсний хэмжээний ном бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор захиалагч болон зохиогч нь дор дурдсан бүтээгдэхүүнийг хэвлэгдэн гарснаас хойш 30 хоногийн дотор номын санд тодорхой хувийг үнэ төлбөргүйгээр хүлээлгэн өгдөг байна.

Хүснэгт 3.Номын сангийн заавал авах хувь

Үндэсний номын санд	Улсын төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн	5 ширхэг
	эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлээс	2 ширхэг
	Монгол Улсын соёлын өвд хамаарах зүйлийн талаар судалгааны бүтээлийг санхүүжилтын эх үүсвэр, хэвлэгдсэн хэл, газрыг харгалзахгүйгээр	2 ширхэг
Орон нутгийн номын санд	орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн хэвлэлийн бүтээгдэхүүн	тус бүр 3 ширхэг
Хүүхдийн төв номын сан	хүүхдэд зориулсан хэвлэлийн бүтээгдэхүүн	тус бүр 2 ширхэг

Номын сангуудын санхүүжилт, ном худалдан авах төсөв жилээс жилд буурч байгаа учир уншигчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн ном хэвлэл худалдан авч сан хөмрөгийг баяжуулах ажил тодорхой түвшинд удаашралтай явагдаж байна.

2016 оноос хойш буюу сүүлийн 5 жилийн байдлаар нийт 8568 нэрийн 21481 ширхэг 397.2 сая төгрөгийн ном бүрдүүлсэн хэдий ч эдгээрээс бэлэг, хандив, гадаад солилцоогоор 6743 нэрийн 13583 ширхэг буюу 207.2 сая төгрөгийн ном авч, худалдаагаар буюу батлагдсан төсвөөр 1825 нэрийн 7898 ширхэг буюу 190 сая төгрөгийн ном, хэвлэл авсан байна.

Хүснэгт 4. Үндэсний номын сангийн сүүлийн 5 жилийн нийт ном бүрдүүлэлт:

Он	Нэр төрөл	Ширхэг	Төсөв /төгрөгөөр/
2016	1734	3909	40 сая
2017	1497	4229	40 сая
2018	1795	4417	40 сая
2019	1706	4532	40 сая
2020	1836	4394	30 сая
Сүүлийн 5 жилд	8568	21481	190 сая

Худалдан авсан номын нэр төрөл, тоо ширхэг жилээс жилд буурч байгаа нь номын хэвлэлтийн өөрийн өртөг нэмэгдэж байгаа, ном худалдан авах төсвийг сүүлийн жилүүдэд бууруулан баталсантай шууд холбоотой байна.

Нийт бүрдүүлсэн номын 60-70 хувийг бэлэг, хандив болон номын солилцоогоор хүлээн авч байна.

Үндэсний номын сан нь улсын хэмжээнд хэвлэгдэн гарч буй хэвлэлийн бүтээгдэхүүн бүрээс худалдан авч, архивын сан хөмрөгийг баяжуулан, хойч үедээ өвлүүлэн үлдээх үүрэгтэй хэдий ч хэвлэгдэн гарсан ном бүрээс ганц хувийг авахад номын үнээс хамааран тэр бүр авч чадахгүй нөхцөл байдал үүсдэг байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 1197 нэрийн 2033 ширхэг 38.6 сая төгрөгийн хэвлэмэл номоор фондын бүрдүүлэлт хийсэн байна.

Эдгээрээс 280 нэрийн 808 ширхэг 9.6 сая төгрөгийн номыг бэлэг хандиваар, 3 нэрийн 40 ширхэг 600 мянган төгрөгийн номыг худалдаагаар, 209 нэрийн 222 ширхэг 3.8 сая төгрөгийн номыг төлбөрөөр, 705 нэрийн 963 ширхэг 24.6 сая төгрөгийн номыг тендерээр тус тус бүрдүүлэн, 2033 ширхэг номонд техник ажиллагаа хийж, 1197 нэрийн 2033 ширхэг номын мэдээллийг электрон каталогт оруулан, 2001 ширхэг RFID-ийн баркодон таг-ыг хэвлэн идэвхжүүлж наасан байна. Мөн АСМТ-ийн 131 нэрийн 138 ширхэг гадаад номонд техник ажиллагаа хийж, номын мэдээллийг электрон каталогт оруулан, баркод хэвлэж наасан байна.

Ном солилцооны хүрээнд нийт гадаадын 12 орны 17 номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай ном солилцоо хийж, харилцаат номын санд 38 нэрийн 223 ширхэг буюу 3 сая төгрөгийн үнэ бүхий номыг илгээсэн бол 325 нэрийн 331 ширхэг буюу 3.6 сая төгрөгийн үнэ бүхий ном, 2 нэрийн 48 ширхэг буюу 122.9 мянган төгрөгийн үнэ бүхий сонин, 170 нэрийн 493 ширхэг буюу 914.5 мянган төгрөгийн үнэ бүхий сэтгүүлийг хүлээн авсан байна.

Номын сангийн санхүүжилт: Номын сан нь Улсын төсвийн санхүүжилт, байгууллагын үйл ажиллагааны орлогоос бүрддэг.

Номын сангуудын санхүүжилт харилцан адилгүй боловч санхүүжилтийн дийлэнх хувь цалин, урамшуулалд харин ном, хэвлэл авах зардалд нийт төсвийн 4-5 хувийг зарцуулдаг байна.

Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр төсвийн төслийг бэлтгэн хүргүүлдэг боловч урьд оны батлагдсан төсвөөс өөрчлөгдөхгүй батлагддаг нь номын сангийн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд хэрэгжүүлэх, номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт хийх зэрэг ажлуудыг орчин үеийн шинэ шатанд гаргахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна.

Хүснэгт 5. Үндэсний номын сангийн нийт санхүүжилт

Он	Санхүүжилт (мян.төг)
2016	958,122.16
2017	983,528.74
2018	1,140,188.66
2019	1,221,015.30
2020	1,938,145.3

Хүснэгт 6. Үндэсний номын сангийн нийт санхүүжилт

Санхүүжилт (хувиар)		
Он	Улсын төсөв	Байгууллагын өөрийн үйл ажиллагаа
2016	97.74	2.26
2017	97.06	2.94
2018	96.76	3.24
2019	96.94	3.06
2020	98.71	1.29

Түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны орлого нь үндсэн үйлчилгээ бус байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан Олон улсын үзэсгэлэн, хэвлэн нийтлэх зэрэг үйл ажиллагаа эрхэлж орлого өсгөх боломжтой хэдий ч “Оюуны өмч”-ийн тухай хууль, “Соёлын өв”-ийн тухай хуулиудтай зөрчилддэг байна.

2019 онд БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан “MNS 5247:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” стандартад үзлэг хийж нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг олон улсын стандартыг судалж, “Эрсдэлийн


үнэлгээ” хийхэд ...номын сангийн орчин нөхцөл стандарт шаардлага хангахгүй байна.” гэсэн үнэлгээ гарчээ. Энэ нь номын сангийн хүний нөөц дутмаг, ном хэвлэл худалдан авах төсвөөс гадна уншигч, хэрэглэгчийн ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийн санхүүжилтээс шууд хамааралтай байна.

Хүснэгт 7.Зардлуудын нийт зарлагад эзлэх хувь

Он	Цалин хөлс, нэмэгдэл	Урсгал шилжүүлэг /тэтгэмж/	Ном хэвлэл	Тогтмол зардал	Бусад зардал
2016	82	-	5	5	8
2017	78	2	5	5	10
2018	70	3	5	4	18
2019	77	0	7	5	11
2020	85	7	4	4	-

Тухайлбал, Үндэсний номын сангийн 2020 оны санхүүжилт Соёлын яамны урсгал санхүүжилтийн 5.7 хувийг эзэлж байна.

Зураг 4.2020 оны нийт зарлагад эзлэх хувь



Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Тайваний Хүүхдийн сангаас “Номын өргөө” төслөөр Ерөнхий боловсролын сургуулийн 20 номын санд дэмжлэг үзүүлж, номын сангийн орчин хүүхдийн хөгжих, сурах боломжийг нэмэгдүүлсэн олон арга хэмжээ зохион байгуулсан байна.
2. “Иргэний номын сан”-гийн загварыг Монголд нутагшуулах, олон улсын жишгээр хөгжүүлэх ажлыг “Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв” ТББ, “Beyond books” төслийн баг хамтран хэрэгжүүлж байна. “Beyond books” төслийг Монгол дахь Австралийн тэтгэлэг, хөтөлбөрийн газар, “Зориг сан”-гаас хамтран хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн манлайлал” хөтөлбөрийн оролцогчид санаачлан хэрэгжүүлж, тус жишиг загварт тулгуурлан Улаанбаатар хотын дүүрэг хороод, орон нутагт “Иргэний номын сан”-гийн туршлагыг түгээхийг зорьж байна.
3. Үндэсний номын сан өөрийн сан хөмрөгт хадгалагдаж буй төвөд ном судрыг каталогжуулан цахимжуулах ажлыг АНУ-д төвтэй хоёр байгууллага болох Азийн сонгодог зохиолуудыг каталогжуулах төсөл (ACIP) болон Буддизмын цахим эх сурвалжууд төвийн (BDRC) санхүүжилтээр 2018 оноос эхлүүлжээ. Энэ хугацаанд 49433 (гарчиг) номыг нэмж каталогт бүртгэн оруулж, дижиталчилсан 3794 ботийн 1,014.519 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд BDRC-ийн tbrc.org болон Үндэсний номын сангийн цахим хуудсанд байршуулж байна. Уг төсөл нь Монгол Улсын ГХЯ, БСШУСЯ-ны зөвшөөрсөн гэрээний дагуу ACIP төслийн 100 хувь хандив, санхүүжилтээр компьютер техник, тоног төхөөрөмжөөр хангасан, төвөд, англи хэлний мэдлэгтэй эх бичиг, шашин судлаач мэргэжлийн 10 ажилтныг сар бүр цалинжуулан ажиллуулж байна.
4. Засгийн газрын “Монгол судлалыг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БСШУСЯ-ны Соёл урлагийг дэмжих сангийн төслөөр 2018 онд Монгол судлалын уншлагын танхимыг байгуулан тохижуулсан ба 2019 оноос ГХЯ, Монгол дахь JCI Олон улсын байгууллагын салбар JCI капитал салбартай

хамтран “Номын элч” сайн дурын аяныг өрнүүлэн гадаадад байгаа монголчуудаас эрдэмтэн судлаачид, оюутан залуусыг уриалан номын хандивыг зохион байгуулж, Монгол Улсын Үндэсний номын сангийн бүрдүүлэлтийн бодлого, чиглэлд нийцсэн монгол судлалын холбоотой гадаад хэл дээрх номуудыг цуглуулах ажлыг зохион байгуулж, тус танхимд 594 номыг хандив, тусламжаар бүрдүүлээд байна.

ГУРАВ.ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Дэлхий нийтэд номын сангийнхаа хөгжлийг нийгмийн хөгжлийн чухал хүчин зүйл гэж тооцон орчин үеийн мэдээллийн технологийн ололт амжилтыг нэвтрүүлэн, номын сангийн үйлчилгээг өргөн цар хүрээтэй, цаг хугацаанаас бага хамааралтай болгож байна. Учир нь номын сан нь иргэд насан туршдаа сурч боловсрох, судалгаа шинжилгээ хийх, шинэ туршлага судлах, бодлогын асуудлаар шинэ мэдээлэл олж авах, ховор хуучин, үнэт ном хадгалах, түүх соёлтойгоо танилцах танин мэдэхүйн түшиц газар болсоор ирсэн.

Улсын Их Хурлаас 2014 онд батлагдсан Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэхдээ уг хуулийн хэрэгжилтийн явц байдал, хуулийн зорилгод хүрч байгаа түвшинг тодорхойлох үүднээс холбогдох мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэлээ.

Гэвч Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад мэдээлэл цуглуулах хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр авсан арга хэмжээ, батлагдсан тушаал, шийдвэрийн хэрэгжилт болон Соёлын яамнаас 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 3/1680 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл нь хангалттай бус байлаа.

Энэ хуулийн хүрээнд нийт 12 журам, 2 жагсаалт, 1 заавар батлагдахаас 7 журам, 1 жагсаалт батлагдаагүй хүлээгдэж байна. Батлагдаагүй журмын хувьд 2 нь боловсруулалтын шатанд, 2 журам нь шинэчлэн батлагдаагүй, 1 журмыг батлах шаардлагагүй гэж үзсэн байна.

Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 8 дүрэм, журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаас одоогийн байдлаар нийт 5 нь батлагдаж, Цахим уншлагын үйлчилгээ үзүүлэх журам, Нөхөн бүрдүүлэх журам, Улсын болон орон нутгийн номын сангийн нэмэлт үйлчилгээ үзүүлэх зэрэг журмуудыг батлаагүй байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн явц зохих түвшинд хэрэгжиж байгаа хэдий ч хуулийн зарим зохицуулалтын хувьд төсөв санхүү, хүний нөөцийн чадавх, салбар хоорондын уялдаа, зохион байгуулалтаас шалтгаалан хангалттай түвшинд хэрэгжихгүй байна гэж үзэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Номын сангийн үйлчилгээг төрөөс дэмжих бодлого алдагдаж, номын сангийн төсөв хөрөнгө хүрэлцэхгүйгээс шинэ номын баяжилт хийх, материаллаг баазаа сайжруулах, уншигчид тав тухтай орчныг бүрдүүлэх, уншлага үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, хүний нөөцөө бэлтгэх зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байгааг анхаарах;

2. Нийт ард иргэдийн дунд ном унших хөдөлгөөн өрнүүлэх, номыг бүтээлчээр унших арга зүйг түгээх, ном унших соёлыг дэлгэрүүлэх үйлсийг дэмжсэнээр үндэсний зан заншил, иргэний нийгмийн соёлыг хамтад нь хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Иймд Номын сангийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангахад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;
3. Ховор ном судрыг гэмтээх, ном судрууд нь түүхэн нөхцөл, хадгалалтын байдлаасаа болоод хэврэгшиж, гараар байнга эргүүлэх боломжгүй болсон байдаг тул цахим хэлбэрт шилжүүлэх, эх хувийн хадгалалт хамгаалалтад анхаарах, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох, судалгааны эргэлтэд оруулах боломжийг нэмэгдүүлэх;
4. Үндэсний хэмжээний номын архив, ном хэвлэлийн бүрдүүлэлтийн бодлого алдагдсанаар төсөв хангалтгүй батлагдах, зарим тохиолдолд номын баяжилт хийгдэхгүйд хүрч үйлчлүүлэгчдийн мэдээлэл хүлээн авах эрх бүрэн хангагдахгүй нөхцөл байдал үүсч байна. Тухайлбал, 2009 онд номын сангуудын ном худалдан авах төсвийг улсын хэмжээнд тэглэснээр тухайн онд хэвлэгдэн гарсан ном хэвлэл өнөөг хүртэл аль ч номын сангийн сан хөмрөгт байхгүй байна.
5. Үндэсний номын сан 3 сая гаруй ном судартай бөгөөд үүний 1 сая гаруй нь монгол, төвд, манж хэл дээр бичигдсэн эртний гар бичмэл болон барын ном судар байна. Эдгээрийн дотор дахин үл давтагдах ганц хувь хосгүй үнэт бүтээлүүд байх бөгөөд эдгээр эх бичгүүд нь өнөөгийн байдлаар зориулалтын орчин нөхцөлд хадгалагдаагүй, байр, талбай хүрэлцээгүйн улмаас хадгалалтын горим алдагдаж хуудас нь хатах, үйрэх, үг үсэг нь баларч бүдгэрэх, нугалаасаараа урагдах, тоос тортогт харлах, хуудсууд нь хоорондоо наалдах зэрэг гэмтэлд ихээр өртөж байна. Иймд Үндэсний номын сангийн шинэ барилгын явцыг шуурхайлах ажлыг зохион байгуулах;
6. Соёлын баримтат өвийн судалгаа, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, эх хувь болон цахим хувийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад Үндэсний номын сан тоног төхөөрөмж бэлтгэгдсэн боловсон хүчний хувьд нөөцийг бий болгосон хэдий ч программ хангамж, мэдээллийн технологийн инженерүүд дутагдалтай байгааг анхаарах;
7. Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн номын сан нь нийтийн номын сангуудаас онцлог ялгаатай, эрдэм шинжилгээний номын сантай илүү ижил төстэй үйлчилгээтэй байх тул Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн номын сангийн статусыг тодорхой болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар арга хэмжээг авах;
8. Хүртээмжтэй форматын ном хэвлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлж, тусгай интернэтийн сувгаар цахим номын сангийн үйлчилгээнд холбогдох цахим сан хөмрөг бий болгох;
9. Цахим номын сан байгуулах талаар олон жил ярьж байгаа боловч энэ ажил едийг хүртэл шийдэлд хүрээгүй яваа нь хэд хэдэн асуудал бэрхшээлээс болж байгаа тул үе шаттайгаар шийдэх;
 - 1) Нарийн мэргэжилтэн бэлтгэх, цахим нөөцийг хэрхэн яаж бүрдүүлэх талаар нэгдсэн байр суурьтай болгох;
 - 2) Оюуны өмчийн хуультай уялдаа холбоогүй байдлыг бодлогоор зохицуулах, эрх зүйн зохицуулалт, журмыг боловсруулах;
 - 3) Программ хангамж технологийн хөгжүүлэлтийг хамтад нь хийлгэх, Олон улсын Цахим мэдээллийн сан хамтран ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх.

10. Номын сан хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбар, чиглэлийн дагуу тодорхой зохион байгуулалтын хэлбэрт оруулах, их, дээд сургууль, хүрээлэнгүүд дундаа ашигладаг нэгдсэн цахим сан хөмрөгтөө болох;

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын
Хяналт шалгалтын хэлтэс

---oOo---